



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 8/22

Шивээговь сум

Д.Баттуултай байгуулсан хөдөлмөрийн  
гэрээг цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, 110 дугаар зүйлийн 110.3, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дугаар “Журам батлах тухай” тушаалын хавсралт “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ын 1.1, 2.8.1 дэхь заалт, ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Санхүүгийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Дамдинсүрэнгийн Баттуул өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн тул хөдөлмөрийн гэрээг 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс цуцалсугай.


2. Д.Баттуулын хариуцаж байсан ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

- |                 |   |
|-----------------|---|
| Комиссын дарга: | Э.Ариунгэрэл<br>(Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)   |
| Гишүүд:         | Б.Энхмаа<br>(Нягтлан бодогч)<br>Б.Ууганбаяр<br>(Архив, бичиг хэргийн эрхлэгч)<br>Б.Мөнхцэцэг<br>(Нярав) |

3. Ажлыг хугацаанд нь зохион байгуулж, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг комиссын дарга (Э.Ариунгэрэл)-д даалгасугай.

4. Д.Баттуулд ажилласан хугацааны мөнгийг бодож олгохыг нягтлан бодогч (Б.Энхмаа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ЦЭРЭНДОРЖ

422220079